

“МАХИМПЭКС” ХК-ИЙН 2014 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Илтгэгч: Ж.Чинзориг “Махимпэкс” ХК-ийн ТУЗ-ийн дарга

2015 оны 04 дүгээр сарын 24

*Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигчид, урилгаар оролцож байгаа эрхэм хүндэт зочид та бүхэнд энэ өдрийн мэндийг Махимпэкс ХК-ийн нийт ажилтнуудын өмнөөс болон хувиасаа хүргэж байгааг хүлээн авна уу.*

Махимпэкс ХК-ийн ТУЗ-өөс 2014 онд хийсэн ажлын тайлангаа та бүхэнд танилцуулан хэлэлцүүлж та бүхний гаргасан үнэтэй санал санаачлага, шүүмжлэлийг цаашдынхаа ажилд тусган хэрэгжүүлэх болно.

Өнөөдөр монголын махны үйлдвэрийн салбарын хөгжил ямар хэмжээнд байна вэ? Сүүлийн жилүүдэд Жаст Агро компани монголын махны үйлдвэрүүдийг худалдан авч бодлого боловсруулан төвлөрсөн хүн амыг үйлдвэрийн аргаар бэлтгэсэн махаар хангахаар асар их хөрөнгө мөнгө гаргаж идэвхи санаачлагатай ажилласан билээ. Гэтэл төрөөс энэ ажлыг дэмжээгүй тул сүүлийн жилүүдэд махны үйлдвэрүүд нь бараг ажилласангүй, ихэнхи үйлдвэрүүд нь өнөөдөр зарагдахаар яригдаж байгаа боловч хэн ч авахгүй байгаа нь махны үйлдвэрийн ирээдүй ямар байгааг бэлхнээ харуулж байна.

Дээрх байдалд дүгнэлт хийж монголын махны үйлдвэрүүдийн санаачлагаар 2013 онд махны салбарыг хөгжүүлж нийгэм эдийн засагт өгөх үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор өнөөгийн хүндрэл бэрхшээл, тулгамдаж буй асуудлыг тодорхойлсны үндсэн дээр тохирох бодлого шийдвэрийг боловсруулсан. Уг шийдвэрийн дагуу дараах зорилгуудыг тавьсан.

- Махыг үйлдвэрийн аргаар боловсруулж эрүүл ахуй чанарын шаардлага хангасан бүтээгдэхүүнийг иргэдэд хүргэх
- Махыг бүтцээр нь ангилан савлаж худалдах

Махны үнэ жил болгон хэлбэлздэг. Энэ хэлбэлзлийг даван туулахад:

- Эрчимжсэн мал аж ахуй байгуулж улирлын чанартай хэрэгцээг багасгана.
- Монгол улсын хэмжээнд эрчимжсэн мал аж ахуй бүрэн утгаараа хэрэгжихгүй байна. Мал нь байгаа ч тэжээлийн болон бордооны асуудлыг цогц шийдээгүй зэрэг дутагдалтай тал их байна.

Иймд:

- Эрчимжсэн мал аж ахуйг цогцоор нь байгуулж олон улсын туршлагыг монгол улсад нэвтрүүлэх
- Ашиг шим, бордооны үзүүлэлт сайтай цэвэр үүлдрийн малын тоо толгойг мах, сүүний хангамжид дорвитойгоор нөлөөлөхүйц хэмжээнд хүргэж олшруулах
- Өсвөр насны малыг тэжээж бордох замаар махны үйлдвэрлэл хангамж, экспортын улирлын хамааралгүй жигд тогтвортой нөхцлийг бүрдүүлэх
- Олон улсын хэмжээнд байгалийн цэвэр бүтээгдэхүүн түүний дотор бэлчээрийн малын мах илүү үнэлэгдэж түлхүү хэрэглэгдэх хандлагатай болж байна. Иймд бэлчээрийн монгол

12

малын махыг газар зүйн заалтад хамруулж гарал үүслийг нь баталгаажуулан түүнийг дагнасан үйлдвэрлэлийг, аль ч улс орны хэрэглэгчдийн сэтгэлд нийцэхүйц орчин нөхцөлд, бүтээгдэхүүнээ тэдний эрэлт шаардлагад тааруулан боловсруулахаар зохион байгуулах хэрэгтэй байна.

Тайлант онд “Махимпэкс” ХК-ийн ТУЗ хиам болон бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлд онцгой анхаарал хандуулж олон улсын жишигт хүргэхээр ISO 9001 чанарын удирдлагын стандарт хэрэгжүүлэн ажиллаж байна. Хиамны үйлдвэрлэл нэмэгдэж, нэр төрөл олширч, ард түмний үндсэн хэрэгцээ банш, буузны үйлдвэрлэл нэмэгдүүлсэнд баяр хүргэж цаашдын үйл ажиллагаанд нь амжилт хүсч байна.

2014 оны бизнес төлөвлөгөөг мал түүхий эд бэлтгэл, үйлдвэрлэл, маркетинг, санхүүгийн үйл ажиллагаатай хамруулан баталж компанийг удирдах үйл ажиллагаандаа компанийн тухай болон бусад хууль тогтоол Махимпэкс ХК-ийн дүрэм, дотоод журмыг мөрдлөг болгон компанийн гүйцэтгэх удирдлагын багийн ажлыг төлөвлөгөөт зорилтыг биелүүлэхэд чиглүүлэн хамтран ажиллаа.

Компанийн гүйцэтгэх удирдлага төлөөлөн удирдах зөвлөлийн удирдамж чиглэлийг биелүүлэн хамтран ажилласныг тэмдэглэхэд таатай байна.

Махимпэкс ХК-ийн ТУЗ-ийн баталсан бизнес төлөвлөгөөний гол зорилт нь 2014 оны мал мах бэлтгэлийн ажлыг сайтар зохион байгуулах, мал, мах бэлтгэлийн явцад өр авлага гаргахгүй байх, үйлдвэрлэлийн техник, технологийн шинэчлэл хийх, мах махан бүтээгдэхүүний гадаад, дотоодын борлуулалтыг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн удирдлага зохион байгуулалтын тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэх явдал байлаа.

2014 оны бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлэх хүрээнд ТУЗ 4 удаа хуралдаж компанийн гүйцэтгэх удирдлагаас тарьсан асуудлыг цаг тухайд нь шийдвэрлэн ажиллаа. Компанийн гүйцэтгэх удирдлага ажил төрлийн шуурхай зөвлөгөөнийг 48 удаа, захирлын зөвлөлийн хурлыг 23 удаа хийж үйлдвэр цех нэгжийн үйл ажиллагаанд хяналт тавьж зохион байгуулалтын арга хэмжээ авч ажилласан болно.

Монгол оронд сүүлийн жилүүдэд малын шүлхий өвчин гарсны улмаас экспорт хийгдээгүй харин 2014 онд ОХУ-д экспорт хийсэн нь бидний давуу тал юм. Харин хонины мах дулааны аргаар боловсруулсан бүтээгдэхүүн экспортлох ажил хийгдэж чадсангүй.

### **НЭГ. ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА БОРЛУУЛАЛТЫН ТАЛААР**

2014 онд үйлдвэрлэлийн үйл ажиллагааг 2 үндсэн чиглэлээр зохион байгуулж ажилласан.

1. ОХУ болон бусад оронд мах экспортлох
2. Дотоодын үйлдвэрлэл (мах махан бүтээгдэхүүн, хиам, хагас боловсруулсан бүтээгдэхүүн)

#### Экспортын үйлдвэрлэл

Тайлант онд ОХУ-д адууны мах 400 тонн, үхрийн мах 400 тонныг тус тус үйлдвэрлэж экспортлохоор гэрээ хийсэн болно. Гэтэл ХХААЯ-аас манай үйлдвэрт үхрийн мах 120 тонн, адууны мах 300 тонныг үйлдвэрлэх хэт бага квот өгсөн тул “Эй Эн Ди Эм” компанитай хамтран экспортлох ажлыг зохион байгуулсан.

Бид “Махимпэкс” ХК дээр адууны мах үйлдвэрлэх, Эрдэнэт хотын Жаст Агро махны үйлдвэрт үхрийн мах үйлдвэрлэх ажлыг зохион байгуулсан. Учир нь шүлхий өвчнөөс болж төвийн бүсэд үйлдвэрлэсэн үхрийн махыг экспортлохыг зөвшөөрөөгүй.

2013-2014 онд өөрийн үйлдвэрт 2700 толгой адуу төхөөрч 390 тонн адууны мах үйлдвэрлэж 100 хувь экспортод гаргасан. Харин Эрдэнэт хотын Жаст Агро махны үйлдвэрт үйлдвэрлэсэн 120 тонн үхрийн мах одоогийн байдлаар экспортод гараагүй байна.

Өнгөрсөн оны экспортын үйл ажиллагаанд дараах хүндрэлүүд учирсныг цохон тэмдэглэж байна.

- ОХУ-д барууны орнууд хориг тогтоосноос болж биднийг гэрээ хийхэд 1 доллар 39 рубльтэй тэнцэж байсан ч үйл ажиллагааны явцад 1 доллар 65 рубльтэй тэнцсэний улмаас мах экспортлох боломжгүй болсон. Үүний улмаас 9 дүгээр сарын сүүлчээр экспортын үйл ажиллагааг бүрэн зогсоосон.
- Рублийн ханшны уналт нь экспортын үйл ажиллагаанд ноцтой нөлөөлж ОХУ-ын талаас үхрийн мах авахыг зогсоож адууны махыг үнэ буулгавал авахаар болсон. Адууны махны үнийг буулгаж 2015 оны 1 дүгээр улиралд экспортлон тооцоо дууссан болно.

Ер нь ОХУ-ын талаас мах авахыг хүсэгчид асар их ирж байгаа ч рублийн ханшийн уналт бусад олон шалтгааны улмаас тэр бүр гэрээ хийгдэхгүй байна. Тайлант онд хонь, ямааны махны экспорт хийгдээгүй учир нь Монгол улсад шүлхий өвчин гарсан учир Ираны тал харзнахаар хариу өгсөн болно.

Цаашид хиам үйлдвэрлэлийн салбарт шинэчлэл хийж хойд, урд хөршид хиам болон дулааны аргаар боловсруулсан бүтээгдэхүүн экспортлохоор ажиллаж байгаа нь сайшаалтай байна.

#### Дотоодын үйлдвэрлэл

Монгол улсын засгийн газар, Монгол банкны хооронд 2012 оны 10 дугаар сарын 22-ны өдөр байгуулсан “Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах” дунд хугацааны хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлэх, харилцан ойлголцлын санамж бичиг, Монгол банкны ерөнхийлөгч, Үйлдвэр Хөдөө Аж Ахуйн Яамны сайдын хамтарсан А-166/А-24 тоот тушаалаар батлагдсан “Хүнсний гол нэрийн бараа бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд Эй Эн Ди Эм ХХКомпанийн туслан гүйцэтгэгчээр ажиллаж 1100 тонн хонины мах, 750 тонн ямааны мах, 720 тонн үхрийн мах бүгд 2570 тонн мах бэлтгэж худалдан борлуулсан болно.

Энэ онд нөөцийн мах хөтөлбөрийн тендерт шалгарч 1200 тонн хонины мах, 900 тонн ямааны мах, 900 тонн үхрийн мах нийт 3000 тонн мах бэлтгэж худалдаанд гаргахад бэлэн болоод байна.

Мах махан бүтээгдэхүүний хамгийн орчин үеийн шаардлага хангадаг инжектор шинээр авч суурилуулсан байна. Мөн үйлдвэрлэл нэмэгдэж байгаа тул орчин үеийн шаардлага хангасан борлуулалтын машин 2 ширхэгийг БНСАУ-аас худалдан авч ашиглаж байна.

Хиам, хагас боловсруулсан бүтээгдэхүүний хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилгоор 2014 онд ХБНГУ-аас шарах камер 2 ширхэг, бүрэн автоматчлагдсан клипсаторыг шинээр нэмж тавьсаны гадна хиамын чанарын шаардлагыг хангах үүднээс мөн улсын Мах холигч шинээр тавьж үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүллээ.

Мөн бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагыг хангах үүднээс үйлдвэрлэлийн процессыг иж бүрэн хяналтын IP камер системээр хянадаг болгон цэвэр усны ерөнхий шугам, цахилгааны кабель трансуудыг шинэчлэн сольж дугаарлан орчин үеийн шаардлага хангадаг болголоо. Мөн үйлдвэрлэлийн аюулгүй ажиллагааны үндэс болсон галын багаж хэрэгсэл, тоноглолуудыг шинэчлэн сольсон байна. Эдгээр ажлыг хийсний дүнд тайланд онд хиам үйлдвэрлэлийн салбарт 1111,3 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн байна. Тайлант онд хиам хагас боловсруулсан бүтээгдэхүүний үйлдвэрлэлд чанарын удирдлагын тогтолцоо (ISO9001:2010)-ийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх гол ажлыг үндсэн удирдлага болгон хэрэгжүүлж чадлаа. Энэ ажлын хүрээнд компанийн удирдлагууд болон нийт ажилтнуудыг 3 удаа үе шаттайгаар сургалтанд хамруулан, технологийн 33 журмыг шинээр, 56 зааврыг шинэчлэн боловсруулж үйл ажиллагаандаа нэвтрүүлэн ажиллаж байна. Чанарын удирдлагын тогтолцоо нь нийт ажилчдын өдөр тутмын ажилд байнгын хяналт сайжруулалт хийж гаргадаг алдаа, үл тохирол бүрийг бүртгэлжүүлэн сэргийлж залруулж ажилладаг болголоо. Үйлдвэрлэлийн нэр төрөл олшруулах, чанар сайжруулах, Европын стандартыг хэрэгжүүлэхээр тайлант онд Польш улсаас өндөр мэргэжлийн технологикийг бүтэн жилийн хугацаанд ажиллуулан ажилчдаа сурган дадлагажуулсан. Тайлант онд хиам үйлдвэрлэлд шинээр 5 нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэхээр ажиллаж байна. Өнөөдрийн байдлаар “Өглөө” нэрийн зайдас үйлдвэрлэж борлуулалтанд гаргаад байна.

Нүүдэл брендийн бүтээгдэхүүнүүд тус компанийн нүүр царай болж хэрэглэгчдээс өндөр үнэлгээ авч байна.

Компанийн нийт ажилчдыг группын амралтанд 50 хувийн хөнгөлттэй үнээр амраасан. Үйлдвэрийн мэргэжлийн онцлогоос шалтгаалж Хэнтий аймгийн Аварга тосон рашаан сувилалд 35 хүн амраасанаас тус компанид олон жил үр бүтээлтэй ажилласан өндөр настан 4 хүн амарчээ.

Үүний дараах компанийн ажилтнуудыг дэлхийн шилдэг техник технологигой танилцуулах зорилгоор АНУ, БНХАУ, ХБНГУ, БНСУ, ОХУ-ын ижил төстэй үйлдвэрүүдтэй танилцуулах, сургалт уулзалт үзэсгэлэн үзүүлэхээр 29 ажилтанг компанийн зардлаар сургаж дадлагажуулсан.

Ажилтнуудын эрүүл мэнд ажиллах таатай нөхцөл бүрдүүлэх ажлын нэг хэсэг болох бялдаржуулах танхим (фитнесс, аэробек, саун) барьж мэргэжлийн багшаар хичээллүүлэн ажиллуулж байна.

**ХОЁР. САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР**

Тайлант онд компанийн эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд болох өртөг, зардлыг бууруулах үргүй зардлыг багасгахад анхаарч тодорхой үр дүнд хүрээд байна.

Тус компанийн 2014 оны санхүүгийн тайлангийн үндсэн үзүүлэлтүүдийг 2013 онтой харьцуулж үзэхэд:

- 2014 онд 20624,6 сая төгрөгний борлуулалт хийж урьд оноос 8552,6 сая төгрөгөөр орлого өсөж ажиллажээ. Үүнээс үндсэн үйл ажиллагааны орлого урьд оноос 11524,1 сая төгрөгөөр өсөж, үндсэн бус үйл ажиллагааны орлого 2971,5 сая төгрөгөөр буурсан байгаа нь эерэг үзүүлэлт юм. Өөрөөр хэлбэл үндсэн үйл ажиллагаандаа голлон анхаарч үйл ажиллагаагаа чиглүүлж ажиллажээ.
- 2014 онд нийт зардал 20217,7 сая төгрөг болж урд оноос 10264,7 сая төгрөгөөр өссөн байна. Өртгийн

15

энэхүү өсөлт нь борлуулалтын орлогын өсөлттэй харьцангуй ойлголт боловч борлуулалтын орлого урьд оноос 11524.1 сая төгрөгөөр өссөн байхад борлуулалтад ноогдох зардал 18682,3 сая төгрөг болж урьд оноос нийт дүнгээрээ 10074,7 сая төгрөгөөр өссөн нь ашиг буурахад нөлөөлсөн байна.

-2014 оны зардлын энэхүү өсөлт нь:

а/ Үндсэн үйл ажиллагааны борлуулсан бүтээгдэхүүний өсөлтөөс гарсан зардлын дүнгийн өсөлт юм.

Үндсэн ажиллагааны зардлаас зээлийн хүүгийн зардалд 114,1 сая төгрөг, шатахууны зардал 7,7 сая төгрөгөөр өссөн байна. Эдгээр зардлын өөрчлөлтөөс гадна борлуулалтын бус ажиллагаанаас зардал 555,3 сая төгрөгөөр өссөн нь борлуулалтын орлогын өсөлттэй холбоотой өсөлт юм.

Тайлант онд 353,1 сая төгрөгийн ашигтай гарч урьд оноос ашиг буурсан боловч Ашигт ажиллагааны түвшин 2013 онд 8,1, 2014 онд 9,7 болж 19 хувиар өссөн нь тус компанийн санхүүгийн үйл ажиллагааны таагүй үзүүлэлт юм.

Санхүүгийн үйл ажиллагааны үзүүлэлтийн нэг гол үзүүлэлт бол эргэлтийн хөрөнгийн эх үүсвэрийн хүрэлцээ түүний тогтвортой ажиллагаа байдаг.

Эргэлтийн хөрөнгийн эх үүсвэр үүнээс нэн түргэн эргэх мөнгөн хөрөнгө 181,7 сая төгрөг, боломжит эргэх хөрөнгө 15870,1 сая төгрөг байгаа нь жилийн үйлдвэрлэлийн үйл ажиллагааг жигд хэвийн хангах үзүүлэлт юм.

Өөрөөр хэлбэл эргэлтийн хөрөнгө хангалттай байна. Дансны авлага урьд оноос 2664,7 сая төгрөгөөр өссөн өөрөөр хэлбэл 4266,0 сая төгрөг байгаа нь эргэлтийн хөрөнгийн чухал эх үүсвэр юм. Гэвч авлагын тооцогдг санхүүгийн алба авлага гарсан он, сар, авлагын найдвартай, найдваргүйгээр нь нарийвчлан бүртгэж авлага өссөн шалтгааныг тайлбар хийж байх шаардлагатай.

Дансны өглөг урьд оноос 3581,5 сая төгрөгөөр бууруулан өглөг авлагын харьцаа өглөг авлагаас 3 дахин их байгаа нь эерэг үзүүлэлт биш боловч борлуулагдаагүй бэлэн байгаа бүтээгдэхүүнээр нөхөх хангалттай эх үүсвэртэй байна.

2014 онд үндсэн бүтээгдэхүүний борлуулалтын орлого 18411,5 сая төгрөг түүнд харьяалагдах зардал 18682,3 сая төгрөг болж үндсэн бүтээгдэхүүний борлуулалтаас 270,8 сая төгрөгний алдагдал гарсан. Өөрөөр хэлбэл үндсэн түүхий эд болох махны бэлтгэлийн үнэ өндөр, мөн түүнийг хадгалах зардал, хадгалалтын хорогдол, ангилалт, савалгааны зардал зэргээс үндсэн үйл ажиллагааны зардал өссөн байна.

Тус компани үндсэн үйл ажиллагааны борлуулалтаас 270,8 сая төгрөгний алдагдалтай гарсан боловч урсгал зардлуудыг хямдруулж ажилласнаар 353,1 сая төгрөгний ашигтай ажилласан байна.

Сүүлийн жилүүдэд мал мах бэлтгэлд өр авлага гаргаагүй ажилласан бөгөөд санхүүгийн үйл ажиллагааны талаар хянан шалгах зөвлөлийн илтгэлд тодорхой тусгагдсан болно.

### ГУРАВ. 2015 ОНЫ ЗОРИЛТ

Бид хиам болон хагас боловсруулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэрлэлийн эхний шат дамжлагаас хэрэглэгчдийн гар дээр очих хүртлэх бүх шат дамжлагадаа ISO 9001:2010 чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлээд байгааг дээр дурьдсан. Энэ олсон амжилтыг бататгаж 2015 онд хүнсний аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо MNS ISO 22000:2007 олон улсын стандарт нэвтрүүлэхээр гол зорилго болгож байна.

- Цаашид олон улсын HACCP (аюулын дүн шинжилгээ эгзэгтэй цэгийн хяналт) стандартыг үе шаттайгаар нэвтрүүлнэ.
- Хэрэглэгчдийн хүсэл сонирхолд нийцсэн хиамыг хүссэн хэмжээгээр жижиглэн савлах зорилгоор Герман улсын хамгийн сүүлийн үеийн савлагааны тоног төхөөрөмжийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх, хиам үйлдвэрлэлд гарч байгаа доголдлыг арилгах зорилгоор металл илрүүлэгч суурилуулах
- Махыг үйлдвэрийн аргаар боловсруулж эрүүл ахуй чанарын шаардлага хангасан бүтээгдэхүүнийг иргэдэд хүргэх, махыг бүтцээр нь ангилан савлаж худалдах
- Дулааны аргаар боловсруулсан бүтээгдэхүүнийг урд хөршид экспортлох
- Жил бүр яригдаж байгаа махны хорогдлын талаар судалгаа туршилт хийж баталгаажуулж үйлдвэрлэлд мөрдөнө.
- Хүнсний бүтээгдэхүүний чанар аюулгүй байдлын баталгаа болсон хүнсний лабораторийг 2015 онд итгэмжлэгдсэн лаборатори болгоно.
- Ажилтнуудыг дэвшилтэт техник технологитой танилцуулах сургалт, үзэсгэлэн үзүүлэх ажлыг уламжлал ёсоор зохион байгуулна.
- Ажилтнуудын эрүүл мэнд ажиллах таатай нөхцөл бүрдүүлэх ажлын нэг хэсэг болох хүн эмнэлэгийг тохижуулж физик эмчилгээний тоног төхөөрөмжүүдийг шинээр худалдан авч үйлдвэрийн ажилчдыг тогтмол үйлчлүүлэх боломжоор хангана.
- Батлагдсан төлөвлөгөөний дагуу үйлдвэрийн техник технологиог шинэчлэх ажлыг цаашид үргэлжлүүлэн хийнэ.

Хувьцаа эзэмшигч та бүхэн Махимпэкс ХК-ийн 2015 оны үйл ажиллагаа, цаашид тавих зорилтод үнэтэй санал гаргана гэдэгт итгэж байна.

Та бүхэнд ажил хөдөлмөрийн амжилт эрүүл энх сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

**АНХААРАЛ ТАВЬСАНД БАЯРЛАЛАА**